



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ
УДИРДЛАГЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 1/03

Улаанбаатар хот

Алсын хараа, эрхэм зорилго,
үнэт зүйлсийг батлах тухай

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам"-ын 136 дугаар зүйлийн 136.4.2 дахь хэсгийн "г", 136.5.2 дахь хэсгийн "г" дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Албаны алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг алба хаагчдад судлуулах, сурталчлах, бодлого, зорилт, үйл ажиллагаанд удирдамж болгож ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс /цагдаагийн хурандаа Д.Пандиймаа/, Статистик мэдээллийн хэлтэс /цагдаагийн хурандаа П.Батбаатар/, Дүн шинжилгээ, судалгааны хэлтэс /цагдаагийн хурандаа О.Зоригоо/, Мэдээллийн технологи, холбооны төв /цагдаагийн хурандаа Ц.Отгонбат/, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв /цагдаагийн хурандаа Н.Амарзаяа/, Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс /цагдаагийн дэд хурандаа Х.Чинтөгс/, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагын хэлтэс, тасгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Албаны алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, өнөө ба ирээдүйн зорилтыг хангахад бодитой хувь нэмэр оруулахыг эрмэлзэж, хичээл, зүтгэл гаргаж ажиллахыг Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны бие бүрэлдэхүүнд уриалсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

ХУУЛБАР ҮНЭН:

Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, цагдаагийн
хурандаа



О.ЗОРИГТ

Д.Пандиймаа

**МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН
АЛБАНЫ АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС**

I. Алсын хараа:

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ХӨТӨЧ, МЭРГЭШСЭН,
МАНЛАЙЛАГЧ АЛБА БАЙНА.

II. Эрхэм зорилго:

ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, БОДИТ МЭДЭЭЛЭЛД
ҮНДЭСЛЭН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ОНОВЧТОЙ ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАЖ
АЖИЛЛАНА.

III. Үнэт зүйлс:

- НАЙРСАГ ХАРИЛЦАА
- ШУУРХАЙ АЖИЛЛАГАА
- ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ
- МЭДЭЭЛЛИЙН УХААЛАГ ТОГТОЛЦОО
- МЭРГЭШСЭН ХҮНИЙ НӨӨЦ
- ЭРЭЛТЭД НИЙЦСЭН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ